



ТӨВ АЙМГИЙН БОАЖГАЗРЫН ХАРЬЯА СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273463 99018619

И-Мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн анги төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2015/136/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 28-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн анги нь 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 29-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, НББ-ийн тухай, хөдөлмөрийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Ойн тухай хуулийн 18.3-д Сум дундын болон сум, дүүргийн ойн анги нь дараах эрх, үүрэгтэй. 18.3.1.ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах, 18.3.2.бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгох; 18.3.3.сум, дүүргийнхээ мод бэлтгэсэн болон хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн газрын ойжуулалтын ажил, ойн хөнөөлт шавж, өвчний тоймчилсон судалгаа гүйцэтгэх; 18.3.4. ойг нөхөн сэргээх, ойжуулах, мод үржүүлэх ажил

эрхлэн модны үр, тарьц, суулгац худалдаалах, ойд учирсан хохирлын экологи эдийн засгийн үнэлгээ тогтоох; 18.3.5.ойн арчилгааны гэрэлжүүлэх, тохируулах огтлолтыг гүйцэтгэх болон сум, дүүргийн ойн хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж хангуулах; 18.3.6.ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх; 18.3.7.ойн баялгийг ашигласны төлбөр, хураамжийг ногдуулж, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах; 18.3.8.аймаг, сумын түвшинд ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох гэх мэт заасны дагуу тухайн байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Ойн тухай хуулийн 18.3.13-д ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих, 18.1.Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 18.1.1.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг батлах, биелэлтэд хяналт тавих;

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн БОАЖГазрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталж Төв аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, ойн тухай хууль зэрэг үйл ажиллагаатай холбогдсон хуулиуд бүрэн хэрэгжиж, Төв аймгийн Байгаль орчны газрын дарга нь Сум дундын ойн ангиудын төсвийн зарцуулалтанд 1-р гарын үсэг зурж байгаа нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно” гэж заасан заалтыг зөрчиж ажилласан байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс БОАЖГазрын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 4 горим сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй БОАЖГазрын бодлогын баримт бичгийг мөрддөг байна.

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг гараар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналттай танилцахад санхүүгийн механизмыг хянадаггүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2014 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 78662.0 мянган төгрөгийн, өөрийн орлогоор 6000,0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан. Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 84662.0 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан ба өөрийн орлогоор 6295.0 мян.төгрөг, нэмэлт санхүүжилтээр Ойн судалгаа хөгжлийн төвөөс 5950.0 мянган төгрөг санхүүжигдсэн, гүйцэтгэлээр 90907.0 мянган төгрөгийг зарцуулж тайлагнасан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 4 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Төв аймгийн Засаг даргын 2013.03.11-ний өдрийн А/121 тоот захирамжийн 1-р хавсралтаар сум дундын Ойн ангийн бүтэц орон тоог Батсүмбэр суман дахь Сум дундын ойн ангийг 4 орон тоотой, Мөнгөн морьт суман дахь сум дундын Ойн ангийг 3 орон тоотойгоор баталсан байна. 2014 онд Батсүмбэр сумын Ойн анги нь 1 орон тоогоор, Мөнгөнморьт сумын ойн анги нь 2 -оор тус тус хэтрүүлсэн. Нийт 12087.1 мянган төгрөгийн цалин, НДШимтгэл 1329.6 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 147-р тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Төв аймгийн Засаг даргын 2013.03.11-ний өдрийн А/121 тоот захирамжаар батлагдсан орон тоогоор ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага бичив.

2. Мөнгөнморьт сумын Ойн ангийн цалингийн сангаас Зуунмод сумын мод үржүүлгийн газрын сахиулын цалинд /гарт олгосон/ 2861.5 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Зуунмод сумын мод үржүүлгийн газрын сахиулын цалин 2861.5 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичлээ.

3. Төв аймгийн Байгаль орчны газрын дарга нь Сум дундын ойн ангиудын төсвийн зарцуулалтанд 1-р гарын үсэг зурж байгаа нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Хуулийн этгээдэд эд хөрөнгө захиран зарцуулах эрх мэдэл хэрэгжүүлэх ажил, албан тушаалд ажилладаг ажилтан адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өмчийн бусад төрөл, хэлбэрийн өмчлөгчтэй эрхэлж байгаа ажил, албан тушаалтайгаа ижил, эсхүл удирдах, хяналт тавих шинжтэй ажил, албан тушаалд ажиллахаар зэрэгцсэн гэрээ буюу контракт байгуулахыг хориглоно” гэж заасан заалт зөрчигдөж байна.

Шийдвэрлэсэн: Сум дундын ойн ангийн төсвийг сумын санхүүгийн албанд шилжүүлж зарцуулах талаар зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох цалин хөлсний асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн ангийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 16278.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2861.5 төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт, 13416.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага бичлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудиторын дүгнэлтээр БОГазрын дарга нь сум дундын ойн ангиудын төсвийг зарцуулах 1-р гарын үсэг зурж буй зөрчлийг арилгах зөвлөмж өгөгдсөн ба зөрчлийг арилгахаар СТСХэлтэст хүсэлт гаргасан боловч сангийн яаманд тоот явуулсан гээд одоо болтол хариу ирээгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Дээрх алдаа, зөрчлийг эс тооцвол Төв аймгийн БОАЖГазрын харьяа сум дундын ойн анги нь төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ